



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 17 өдөр

Дугаар A/90

Ховд

Г Т
Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Дөргөн сумын төвийн тохижилтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Ш.Нохойжав – Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд: Т.Дариймаа - Дөргөн сумын Засаг даргын орлогч

Д.Нямжаргал – Төрийн бус байгууллагын төлөөлөл

Ц.Баяржаргал - Иргэн

Нарийн бичгийн дарга:

Ж.Батлхагва – Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа харилцаа хариуцсан мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо / Ш.Нохойжав /-нд үүрэг болгосугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга / Ж.Батлхагва /-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ЭНХБОЛД



2019 тг A/90 Ch
02 00393